

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 5340.3 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 8.9 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 2502.9 сая төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 0.4 хувиар тасарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 4934.6 сая төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 31.8 сая төгрөгөөр дээгүүр байна. Дарьганга, Түмэнцогт, Баруун-Урт сумд 2.1-9.7 хувиар тус тус хэтэрсэн гүйцэтгэлтэй байна.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 16.9 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 3.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 10.5 тэрбум төгрөг болсон нь 2009 оны жилийн эцсээс 3.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн банкуудын хугацаа хэтэрсэн зээл 0.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Ургац хүраалт, хадлан бэлтгэл: 8 сарын байдлаар ургац хураалт эхлээгүй байна.

Өвөлжилтын бэлтгэлтийг сумд хангаж эхлээд байна. Нийт 1531 тн хадлан, 272 тн гар тэжээл бэлтгээд байна. Үүнээс ААНБ 500 тн, иргэд 1031 тн хадлан, ААНБ 25 тн, иргэд 247 тн гар тэжээл тус тус бэлтгээд байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 18.4 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеийнхээс 2.4 тэрбум төгрөгөөр доогуур байна.

Оны үнээр 69 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 50.2 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлөөс цайрын баяжмал, нарийн боов, өнгөт тоосгоны үйлдвэрлэлт доогуур байна.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний үнийн индекс 8-р сард 2009 оны жилийн эцсийнхээс 1.7 хувиар өссөн хэдий ч урьд сарыхаас 0.4 хувиар буурлаа. Энэ нь Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.3 хувиар буурсан байна. Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үний бууралтад хүнсний бараа үүн дотроо мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний үнэ 5.0-14.1 хувиар буурсан гол нөлөөлсөн байна.

**VII. ЭРҮҮЛ МЭНД:** 770 эх амаржиж, 779 хүүхэд амьд төрсөн байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 20 болж урьд оны мөн үеэс 11-ээр олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 326 болж, урьд оны мөн үеэс 214-өөр доогуур байгаагийн дотор вирус гепатит, салхинцэцэг, тэмбүү, заг, трихоминиаз зэрэг өвчнүүд буурсан байна.

**VIII. АЖИЛГҮЙЧҮҮД:** Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1277 болж, урьд оны мөн үеийнхээс 18 хүнээр доогуур гүйцэтгэлтэй байна. Ажилгүйчүүдийн 70.2 хувь нь 16-34 насны залуучууд, 18.6 хувь нь дээд, 3.4 хувь нь тусгай дунд, 35.6 хувь нь бүрэн дунд, 8.3 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

1788 хүн шинээр бүртгүүлж, 1485 хүн ажилд орсон байна.

Шинэ ажлын байранд ажиллаж байгаа хүний тоо 446-т хүрчээ.

**IX. ГЭМТ ХЭРЭГ:** 114 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4-өөр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 28 хүн нас барж, 24 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 85.5 сая төгрөгийн хохирол учирсны 77.9 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 99 хүн холбогдон сэжиглэгдсэний 19.2 хувь нь согтуугаар, 15.1 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1626 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 270 хүнээр доогуур байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 75 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Хэрэг илрүүлэлт 100.0 хувьтай байна.

## АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС